МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025.09.25 № 05/16328.
танай ______ -ны № ______ -т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД
ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ
ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны шинжээчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Мягмарсүрэнгийн Болортуяа, Бат-Эрдэнийн Болд, Чинбатын Энхчулуун, Төмөрбаатарын Гантуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн шинжилгээ хариуцсан Засгийн газрын ахлах референтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Болдын Ундрал, Салбарын бодлого, зохицуулалтын газрын аж үйлдвэр, эрдэс баялаг, хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын асуудал хариуцсан Засгийн газрын ахлах референтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Даваадоржийн Балжинням нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР М.ДАВААТОГТОХ

УХА0422 5120529

14250301 620

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар
Бичиг хэрэг
Огноо 2025.09.29
09 цаг 00 минут